

МОНГОЛ ХҮҮХДИЙН ҮГ, ӨГҮҮЛБЭР БҮТЭЭХ ЧАДАМЖИЙН ТУХАЙД

Б.Мөнгөнцэцэг

**Түлхүүр үг:** *хэл ярианы хөгжил, үгсийн аймаг, өгүүлбэрийн хэв шинж, төгсгөх нөхцөл, үүсмэл үг*

Хүүхэд гэдгийг олон улсад бага болон дунд гэсэн “түвшин”-д авч үздэг байна. Нэгдсэн Үндэстний Байгууллага “Найм хүртэлх насны хүүхдийг бага насны хүүхэд” гэж тодорхойлдог ч сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг тооцох албан ёсны статистик мэдээнд 3-5 насны хүүхдийг хамруулан тооцдог ([www.unicef.org](http://www.unicef.org)). Хүүхэд насны дунд үед 6-14 насныг хамааруулж тодорхойлсон байдаг бөгөөд энэ насандаа сургуульд элсэж, найз нөхөдтэй болж, бие махбодын болон танин мэдэхүйн шинэ чадварт суралцаж, бие даасан байдалтай болдог ба энэ насны хүүхдийн онцлог нь сурах үйл ажиллагаа давамгайлсан нийгмийн хэрэгцээ их байдагтай холбон үздэг байна (<http://acei.org/>). Аливаа хүний насан туршдаа хэн байхыг нь тодорхойлох энэхүү чухал насанд нь хамгийн зөвөөр нөлөөлөх боломж бол хүүхдийн зохиол, сурах бичиг, гарын авлага байдаг. Хүүхдэд зориулсан тэдгээр бүтээлийг өнөө цагт шинжлэх ухааны үндэслэлтэйгээр бүтээн туурвих явдал хамгийн чухал юм. Гэхдээ сэдэв, агуулгын хувьд хүүхдэд зориулагдсан хэдий ч үгийн сонголт, бичлэгийн арга, хэл найруулга зэрэг нь насанд хүрэгчдийн түвшинд нийцэхээр болдог нийтлэг дутагдал ажиглагддаг. Тодруулж хэлбэл, хүүхдэд зориулсан сэдвийг сонгон аваад өөрийн үгийн сангийн нөөцийг ашиглаж, чөлөөтэй найруулан бичдэг гэсэн үг. Тэгэхээр хүүхдэд зориулсан аливаа бүтээлийн үгийн сан, өгүүлбэрийн бүтэц, найруулгын хэв маяг зэргийг хүүхдэд ухаж ойлгоход төвөггүй байхаар боловсруулан бичих шаардлага зүй ёсоор тулгарч байна. Ийм нөхцөл боломжийг бүрдүүлэх үндсийн нэг нь хүүхдийн үг, өгүүлбэр бүтээх чадамжийг тодорхойлон тогтоох явдал юм.

Монгол хүүхдийн эх хэлээ эзэмшиж буй талаар нарийвчлан судалсан судалгаа хангалттай биш байна. Харин сүүлийн үед сургуулийн өмнөх насны хүүхдийн сэтгэл зүй, ярианы чадварын талаар судалгаа гарч байгааг үгүйсгэх аргагүй. Тухайлбал, Т.Цэндсүрэн (2002) “5-7 насны хүүхдийн оюун ухаан ба нийгэмшихүйн хөгжлийн хамаарлын судалгаа” (Цэцэрлэг, “Хот айл” төсөлд хамрагдаж буй хүүхдүүдийн жишээн дээр), Ц.Баттуяа (2003) “Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн хөгжлийг судалсан нь” (Цэцэрлэгийн 4-7 настай хүүхдийн жишээн дээр), Ц.Наранцэцэг (2007) “Хүүхдийн утгын уялдаатай ярих чадварын судалгаа”, Ц.Оюунгэрэл (2004) “Турав хүртэлх насны хүүхдийн хэл ярианы хөгжилд үзүүлэх орчны нөлөөлөл”, С.Одончимэг (2014) “Хүүхдийн хэл ярианд үүсмэл үг үүсэх онцлог зүй тогтол” (3-6 насны хүүхдийн хэл ярианы ажиглалт, туршилт судалгаа) зэрэг судалгааны ажлууд гарсныг дурдах нь зүйтэй.

Хүүхдийн хэл ярианы хөгжлийн онцлогийг судлахдаа тэдний сэтгэц, сэтгэхүй, мөн эд юмстай харьцах, тэдгээрийг ашиглаж хэрэглэх хэрэгцээ чадвар нь хэрхэн төлөвшиж байгаа зэрэг ерөнхий орчинтой нь холбон авч үздэг байна. Учир нь, хүн хэлтэй болно гэдэг нь хүүхэд цагаасаа эхлэн хэлэхүйн үйл ажиллагааны арга, хэрэглүүрийг эзэмших чадвар дадал

хэрхэн бүрэлдэж төлөвших асуудлыг гол үндэс болгож байгаатай нягт уялдаатай байдаг. Ялангуяа хэлний янз бүрийн нэгжүүдийн утга, хэлзүйн айг хэрхэн хийсвэрлэн ойлгож байгааг тодорхойлох асуудал зүй ёсоор тулгамдах болжээ. Зургаан настай хүүхэд гэдэг бол төрөлх хэлээрээ нэгэнт саадгүй харилцаж чаддаг болсон хэдий ч 14 нас хүртэл нь хэлний нэгжүүдийн утгыг айчлан хийсвэрлэж, чөлөөтэй хэрэглэх чадвар харьцангуй удаан төлөвшдөг учраас уг үйл явцыг бүрэн дүүрэн нээж илрүүлэхийн зэрэгцээ түүнийг зохистой дэмжин хөгжүүлэх арга замыг нэгэн зэрэг нээн олсоор байх учиртай гэж үздэг. Өөрөөр хэлбэл, хүүхдийн нас, сэтгэцийн онцлогт нь тохирсон танин мэдүүлэх, таньж мэдсэн зүйлээ хэлээр зөв илэрхийлэх чадвар эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагааг гэр орон, сургуулийн орчинд тасралтгүй, үр ашигтай, оновчтой зохион байгуулах ёстой болдог. Үүнтэй холбогдуулан нэгэн судалгааг авч үзье.

Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яамны захиалгаар 2013-2017 онд хэрэгжүүлсэн “Монголын хүүхэд, залуусын хөгжлийн шалгуур, үзүүлэлтийг тодорхойлох технологийг сургалтын практикт нэвтрүүлэх нь” сэдэвт төслийн хүрээнд 6-21 насны хүүхэд, залуучуудын танин мэдэхүйн чадварыг судлахдаа хүүхдийн сэтгэл зүйн онцлогийг харгалзан ажигч чанар, анхаарлын тогтворжилт, шилжилт, ажиллах чадвар, богино хугацааны хараа, сонорын ой, утгын ой тогтоолт, сэтгэхүй, сэтгэхүйн харьцуулах үйлдэл зэргийг; хэл ярианы хөгжлийг судлахдаа үгсийг утгаар нь бүлэглэх, үг тайлбарлах, зураг хараад ярих чадварыг судлах аргачлалуудыг ашигласан байна. Н.Бэгз, С.Санжаабадам нар хэл ярианы хөгжлийг оношлох даалгаврыг авч үзэхдээ “нэгдүгээрт, хэл шинжлэл талаас нь ойлголтын төлөвшил буюу үгийн утгыг эзэмших, идэвхтэй хэрэглэж буй үгийн тоо, өгүүлбэр зүйн хэрэглээ буюу энгийн, нийлмэл, учир шалтгааныг заасан нийлмэл өгүүлбэрийн хэрэглээ; сэтгэл зүйн талаас нь үгийн утгын хийсвэрлэлийн түвшин, сэтгэхүйн нэгтгэн дүгнэх чадвар зэргийг хэл ярианы хөгжлийн үзүүлэлт болгон даалгаврын сонголт, боловсруулалтыг хийсэн.

Үгийн утга эзэмшихүйг ихэнх тохиолдолд ойлголтын төлөвшил хэмээн нэрлэдэг бөгөөд үгийг түүний гол шинжид нь тулгуурлан тайлбарлах, утгын ижил төсөөтэй шинжээр нь бүлэглэх даалгавраар судлахаар сонгосон.

Зураг хараад тайлбарлах даалгавар нь хэрэглэж байгаа өгүүлбэрийн төрөл, гадаад шинж байдлыг тоочих эсвэл утга санааг нэгтгэн дүгнэх чадвар зэргийг оношлоход чиглэнэ” (2018а:20-21) гэжээ. Түүнчлэн Н.Бэгз, С.Санжаабадам нар (2018в) уг төслийн хүрээнд “Монголын хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих нь” зөвлөмжийг гаргасан бөгөөд энэхүү зөвлөмжид насны ангилал тус бүрд онцлогийг дурдахын зэрэгцээ сургалтын хөтөлбөр, сурах бичиг боловсруулах түвшинд; эцэг, эхийн зүгээс; сургууль, багшийн түвшинд юуг анхаарах ёстойг тус тус ялган үзсэн байна.

Түүнчлэн Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яамны захиалгаар 2015-2017 онд хэрэгжүүлсэн “Монгол хүүхдийн үгийн сангийн чадамж, нөөцийг тодорхойлох нь” сэдэвт суурь судалгааны төсөлт ажлын хүрээнд 7-12 настай монгол хүүхдийн суурь үгийн санг шинжлэн тогтоох судалгааны үр дүнд “Сурагчийн монгол хэлний тайлбар толь”-ийг боловсруулан гаргажээ. Урьд өмнө манайд гарсан хүүхдийн үгийн сангийн толь бичгүүд байдаг боловч энэхүү толь бичиг нь анх удаа бодит судалгаанд үндэслэсэнээрээ давуу талтай байна. Уг төслийн тайланд “Судалгааны үр дүнд 2-7-р ангийн 2275 хуудас зохион бичлэгийг хэрэглэгдэхүүн болгон зөв бичгийн дүрмийн алдааг засаж үг бүрийн үндсийг автоматаар олж салаа утгатай болон ижил үгийн утгыг гараар тэмдэглэсэн. Сурагчийн бичсэн, ярьсан 33000 үг, тоо тэмдэгтээс 3-аас дээш давтамжтай 3450 үгийг бодит үгийн сан болгон сонголоо.

Сурагчийн мэдвэл зохих үгс (мэдлэгийн үг)-ийг бүрдүүлэхийн тулд сурах бичгийн үг, нийтийн хэрэглээний хамгийн их давтамжтай үгсийн жагсаалтыг гаргаж хүүхдийн хэрэглээгүй, их давтамжтай 1267 үгийг нэмж толгой үг болгон орууллаа. Ойролцоогоор нийт 5000 орчим үг бүрдсэн. Бүрдсэн толгой үг бүрд утгын тайлбар, давтамжийн тэмдэглэгээ, монгол бичгийн хэлбэрийг хадсан. Тайлбарыг өмнө гарч байсан монгол хэлний 5 толийн

тайлбаруудыг харьцуулан, бага насны хүүхдийн нас сэтгэхүйд тохирсон байдлаар буюу энгийн хялбар үг хэллэгийг сонгон товч тайлбарлалаа. Толь бичгийн тайлбарыг хийхдээ бүтээлч хандахыг чухалчилсан. Энгийн академик түвшний тайлбар толь, хүүхдэд зориулсан тайлбар толь хоёр бол ялгаатай. Тайлбарыг аль болохоор энгийншүүлж, шаардлагатай нөхцөлд зураг хэлбэрээр таниулан тайлбарлах аргыг сонгож авсан. Бага ангийн хүүхэд уншаад ойлгож чадаж байна уу, үгүй юу гэдэг дээр судалгаа хийж ажилласан” (Мөнгөнцэцэг, Заяабаатар, Эрдэнэ-Очир, Золжаргал, Бямбацэрэн, Энхжаргал, Мөнхбат нар, 2019:49, 65) гэжээ.

“Монгол хүүхдийн үгийн сангийн чадамж, нөөцийг тодорхойлох нь” сэдэвт төслийн хүрээнд зохион бичлэг болон ярилцлага гэсэн хоёр аргаар хөмрөгийг бүрдүүлэхэд судалгааны 7 нэгжид хамаарах 2-7-р ангийн 2190 сурагч оролцсон бөгөөд уг хөмрөгөөс бид судалгааны ажлынхаа зорилгод нийцүүлэн төлөөлөл болгож: а) Төв суурин газарт: Улаанбаатар хотын төв хэсгээс төлөөлөл болгон 18-р сургууль, захын хорооллоос төлөөлөл болгон 39-р сургууль, б) хөдөө орон нутагт: баруун бүсийн говийн хэсгээс төлөөлөл болгон Говь-Алтай аймгийг сонгосны зэрэгцээ харьцуулж дүн шинжилгээ хийх үүднээс хүүхдийн тоо (нэгж тус бүрээс 30-нийг 90 хүүхэд)-г тэгшилсэн болно. Тодруулбал, судалгааны 3 нэгжид хамаарах 3-р ангийн хүүхдүүдийн өгүүлбэр бүтээх чадамжийг хэл шинжлэлийн үндэслэлтэйгээр тогтоон гаргахын тулд зөвхөн бичгийн хэлний түвшинд судлан тодорхойлсон болно. Тодруулбал, бичгийн хэлийг судлахын тулд тодорхой чиглэсэн сэдвээр 3 удаагийн зохион бичлэг хийлгэж судалгааны фонд бүрдүүллээ.

Судалгааны фондын хэрэглэгдэхүүнд боловсруулалт хийж, 8 настай хүүхдийн өгүүлбэр бүтээх чадамжийг тодорхойлон гаргахдаа

Үгсийн аймгийн бүрэлдэхүүн

Өгүүлбэрийн хэв шинж

Өгүүлбэрийн төгсгөл болоод төгсгөх нөхцөлийн хэрэглээнд дүн шинжилгээ хийлээ. Тус бүрийг тодруулан авч үзье. Үүнд:

а. Бидний судалгаанд хамрагдсан 3-р ангийн нийт 90 сурагчаас авсан зохион бичлэгийн үгсийн аймгийн харьцааг авч үзвэл нийт 69515 үгийн 29200 буюу 42%-ийг нэр үг, 17894 буюу 26%-ийг үйл үг, 6761 буюу 9.7%-ийг тэмдэг нэр, 6547 буюу 9.4 %-ийг төлөөний үг, 3165 буюу 4.5 %-ийг тооны нэр, 2291 буюу 3.3 %-ийг баймж үг, 2049 буюу 2.9 %-ийг холбоос үг, 1608 буюу 2.3 %-ийг орон цагийн нэр эзэлсэн байна.

б. Өгүүлэхүүний төвөөр энгийн өгүүлбэр, нийлмэл өгүүлбэр гэж ялгасны зэрэгцээ нийлмэл өгүүлбэрийн төгс биш өгүүлэхүүний утгын холболт, хэлбэржилтээр нь “ЗНӨ, УНӨ, ХЗНӨ, ХоНӨ” гэж дотор нь нарийвчлан ялгаж үзлээ. Бидний судалгаанд хамрагдсан 3-р ангийн нийт 90 сурагчаас авсан 17 сэдэв бүхий зохион бичлэгийн өгүүлбэрийн хэв шинжийг авч үзвэл нийт 2691 өгүүлбэрийн 58.9 % нь энгийн өгүүлбэр, 41.1% нь нийлмэл өгүүлбэрээс бүтсэн байна.

в. Өгүүлбэрийн төгсгөл болоод төгсгөх нөхцөлийн хэрэглээг авч үзэхэд, 60% нь тодотгон холбохын нөхцөл, 12% нь цагаар төгсгөх нөхцөл, 2% нь биеэр төгсгөх нөхцөл, 26% нь хувилбар гишүүнээр хэлбэржсэн болох нь хэлний баримтаас харагдаж байна.

Түүнчлэн үе үеийн нэрт судлаачид оюун ухаан-танин мэдэхүйн хөгжлийг судлахдаа ухагдахуун-сэтгэхүйн хоорондын холбоо хамаарлыг хөгжлийн нэг бүтэц болгон судалсаар ирсэн. Тухайлбал, Векслер оюун ухааны сорил (WPPSI, WISC) нь ойлголтын төлөвшил, үгсийн санг оношлох даалгавруудтай ба энэ нь 3-7 насанд зураг хараад тайлбарлах, нэрлэх, түүнээс дээш насанд үг тайлбарлах, үгс хоорондын адил төсөөтэй шинжийг олох даалгавраас бүрддэг байна. А.М.Шахнарович, Н.М.Юрьева нар “Хэл ярианы хөгжлийг танин мэдэхүй, харилцааны нэгдмэл үйл явц бөгөөд юмс үзэгдэл ба түүнийг тэмдэглэж байгаа үг хоёрын хооронд холбоос үүсгэж байгаа нь хэл ярианы хөгжлийн үндэс” (1990:19) гэж тайлбарлажээ. Мөн А.А.Леонтьев “Хэл яриа ба сэтгэхүйн холбоо нь хүний хэл яриан дахь утга санаагаар илэрч байдаг зүй тогтолтой тул хэл яриаг сэтгэхүйн үйлдлээс салангид

авч үзэх боломжгүй. Хэл яриан дахь утга санааг үгийн утгыг хэрхэн эзэмшсэнээр нь тодорхойлно. Хэл ярианы хөгжил нь амьдрал үйл ажиллагааны явц дахь үгийн хэрэглээний нийтлэг онцлог, сэтгэхүйн нэгтгэн дүгнэх чадвар, хувь хүний зан төлөвтэй холбоотойгоор хөгждөг” (1969:67, 83) хэмээн онцлон тэмдэглэсэн байна. О.С.Ушакова (1980) хүүхдийн хэл ярианы хөгжлийг 0-1, 1-2, 2-3, 3-4, 4-5, 5-6, 6-7 гэсэн насны үечлэлээр авч үзжээ.

“6-12 наснаас хүүхдэд ухагдахуун төлөвшил эрчимжин, үгийн олон утгыг мэддэг болно. Энэ нь тэдний хийсвэр сэтгэхүйн хөгжил, сургалтын үйл ажиллагаатай холбоотой юм. Жишээлбэл: нохой шиг гэж ярихад 2-5 настай хүүхэд зөвхөн өөрийн мэддэг нохойтой л холбож ойлгодог бол 6-7 настай хүүхэд ерөнхийд нь нохой гэдэг амьтан талаас нь ойлгоно, нас дээшлэх тусам бусад амьтантай холбох мөн гэрийн тэжээвэр амьтан талаас нь ойлгох цаашлаад нохойны зөвхөн шинж тэмдгийг нь хийсвэрлэн ойлгох, тухайлбал, 12 настай хүүхэд нөхөрсөг, үнэнч гэх мэт зан чанарыг нохойтой харьцуулсныг ойлгох чадвартай болдог байна (Бэгз, Санжаабадам нар, 2018б:71). Ингэхлээр хүүхдийн хэл ярианы хөгжлийн үе шатыг авч үзнэ гэдэг бол чухамдаа хэлний айн утга үүргийг хүүхэд ойлгож, хэрэглэх чадвар хэрхэн төлөвшиж байгааг авч үзнэ гэсэн үг юм. Учир нь, хэлний ай болгон төдийгүй, хэлэхүйн үйл ажиллагааны бүтэц болгоны хамгийн гол, үндсэн асуудал нь УТГА нэвт шингэсэн үзэгдэл байдаг бөгөөд энэ нь хэлний чадвар хэмээх үүргийн бүхэл бүтэн тогтолцоог бүрдүүлдэг (Шахнарович, Юрьева нар, 1990:4-19).

Хэлний тэмдэг нь авианы тэмдэг, үсгийн тэмдэг гэх хоёр хэлбэртэй байдаг. Авианы тэмдэг нь анхдагч, бичгийн буюу үсгийн тэмдэг нь хоёрдогч буюу Ш.Лувсанвандангийн тодорхойлсноор, үсэг нь “тэмдгийн тэмдэг” болдог. Зургаан настай хүүхэд сургуульд орохоос өмнө зөвхөн авианы тэмдгээр харилцаж байсан бол сургуульд орсон цагаас эхлээд үсгийн тэмдгийг шинээр эзэмшиж, түүнийг авианыхаа тэмдгийн тэмдэг болгон хэрэглэж сурна гэсэн үг юм. Ингэхлээр, юмын дүр дүрсийг төрөлх хэлнийхээ авианы дүр дүрстэй авалцуулан холбож, авианы хэлээр харилцаж байсан бол цагаан толгой эзэмших явцад авианы тэмдгийг үсгийн тэмдгээр авалцуулан илэрхийлэх танин мэдэхүй, сэтгэхүйн шинэ аргад суралцана гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, хэлэхүйн үйл ажиллагааны явцад юм, түүнийг орлох үгэн тэмдэг хоёрын хоорондох уялдаа холбоо хэрхэн хөгжиж байгааг голлон анхаарах учиртай болно.

Юм, үзэгдлийг үгтэй холбох, түүнийгээ дам үсэг бичгээр илэрхийлэх сэтгэц-сэтгэхүй-хэлний энэхүү холбоо хамаарал нь гагцхүү нийгмийн харилцааны хүрээнд л хэрэгжих боломжтой байдаг ажээ (Серебренников, 1983:63, 74). Энэ нь үзсэн сонссон зүйл төдийгүй, таньсан мэдсэн, ухаарч ойлгосон зүйлээ бусдад хэлээрээ илэрхийлэх, мөн харгалзах уг юм, үзэгдлийн талаар бусдын таньж мэдсэн, ухаарч ойлгосон зүйлийг хүлээн авч, туршлага мэдлэгийнхээ байдлыг харьцуулах сэдэл, хэрэгцээтэй нь нягт уялдаатай байдгийг сэтгэхүй, хэлний хөгжлийн үе шатны онцлогоос нь ангид авч үзэх боломжгүй гэж үздэг байна. Үүнтэй уялдаад хэлний тэмдгийг утгаас нь саланги авч үзэх ямар ч боломжгүй гэдэг.

Хэлээр харилцах буюу юм үзэгдэл, үйл явдал, шинж чанарыг хэлний тэмдгээр илэрхийлэхийн тулд дараах хоёр үйл ажиллагааг гүйцэтгэх буюу шийдвэрлэнэ гэсэн үг юм. Үүнд, 1. Харилцааны нөхцөл байдлыг задлан шинжлэх, 2. Энэ нөхцөл байдлын хамгийн гол гэж үзэх бүрэлдүүлбэрүүдийг сонгож авах явдал юм. Тухайн нөхцөл байдлын гол бүрэлдүүлбэрийг зөв таньж, зөв сонгосноор түүнийг илэрхийлэхэд тохирох хэлний тэмдэг, түүний бүтэц байгууламжийг сонгоно гэсэн үг юм. Харилцааны нөхцөл байдал гэдэг нь өнгөцхөндөө “зам асуух”, “унаа хэрэглэх”, “зоогийн газарт”, “үзмэрийн газарт”, “эмнэлгээр үйлчлүүлэх” гэх мэт сэдэвтэй байж болно гэж төсөөлж болох ч гэсэн нөхцөл байдлыг задлан шинжлэх, түүний гол бүрэлдүүлбэрийг сонгох мэт үйл ажиллагаа нь зөвхөн өмнө тэмдэглэсэн нөхцөл байдал буюу тухайн сэдвийн хүрээгээр тодорхойлогдож байгаа зүйл биш, харин юм хийх, юмстай харьцах үйлдэл, үйлийн программ буюу эрэмбэ дарааллын иж бүрдэл хэрхэн хөгжиж байгаагаас шалтгаалж, түүний шинж чанараар л тодорхойлогдож

байгаа зүйл гэж үзвэл зохих юм. Ингэхлээр энэ программын хөгжлийн шинж байдал нь хэлэхүйн үйлдлийн дотоод оньсыг өөрчилж хөгжүүлэх арга болдог бөгөөд сургуулийн өмнөх болон сургуулийн насны эхний үед хамаарах хүүхдийн сэтгэхүй, сэтгэц, хэл ярианы хөгжлийн анхдагч үе шатуудын нэг хэмээн онол, арга зүйн нэг үндэслэл болгодог байна (Шахнарович, Юрьева нар, 1990:43). Үүнийг үг бүтэх ёсны жишээгээр авч үзвэл, “сургуульд явж байгаа хүүхэд” гэдэг нөхцөл байдлыг зөв утга, бүтэцтэй нь үгээр илэрхийлэхийн тулд тухайн хүүхэд, түүний хаана, юу хийдэг (сургуульд явдаг нь)-ийг өөр хооронд нь холбон хамаатуулсны үр дүнд энэ нөхцөл байдал буюу үйл ажиллагаа хэрэгжих арга, онцлогийг зөв төсөөлж ойлгосноор түүнийг нэг цогц илэрхийлэл болгон нэрлэх хэрэгцээ хүүхдэд бий болж, түүний үр дүн буюу хэлний тэмдэг нь “сурагч”, эсвэл “сурахчин”, үгүй бол “сургуульчин” гэдэг үг ч хэрэглэж болзошгүй юм. Сургуульд анх элсэж байгаа хүүхэд буюу 6, 7 насныхан шинэ юм үзэгдэл, шинэ нөхцөл байдлыг нэрлэхдээ их төлөв дэлгэрэнгүй өгүүлэмж буюу хоёроос дээш энгийн өгүүлбэрээр илэрхийлэхээс гадна дан үг хэрэглэх, заримдаа үүсмэл үг хэрэглэж чаддаг болсон байна. “Сургуульд явж байгаа хүүхэд” хэмээх нөхцөл байдлыг 6-8 насныхан “цүнх үүрсэн хүүхэд, сургуулийн хүүхэд, сургуульд явж байгаа хүүхэд, сургуульд орсон хүүхэд, миний дүү, бэлтгэл ангийн хүүхэд” гэх мэт, эсвэл “сургуульчин, ном сурах хүүхэд, эрдэм сурах хүүхэд, сурахчин” гэх мэтээр илэрхийлэх боломжтой нь насанд хүрсэн хүний хувьд инээдэмтэй, “тэнэг” явдал шиг санагдавч энэ мэт үзэгдэл баримт нь хүүхдийн танин мэдэхүй, сэтгэн бодох үйл ажиллагаа нь хувирч өөрчлөгдөж, хувьсаж хөгжиж байгааг гэрчлэх баримт болно. Хүүхэд биет юмстай харьцахдаа хатуу зөөлөн, халуун хүйтэн, хавтгай бөөрөнхий гэх мэт физикийн тал буюу бодисын шинжээр нь биш, харин тухайн юмыг чухам ямар үйлд, ямар зүйлд, яаж хэрэглэдэг үүргийнх нь шинж, бас бусад юмтай ямар холбоо хамааралтай байгаа талаас нь хандаж байгаа нь ялангуяа 6-аас дээших насны хүүхдэд тодорхой мэдрэгддэг байна. Энэ нь юмыг задлан шинжилж, нэгтгэн дүгнэх оюун ухааны үйл ажиллагааны хувьсал хөгжлийн онцлогтой нь холбоотой байдаг гэж үздэг ажээ.

Байгаль, нийгмийн аливаа юм үзэгдэл болгон маш олон талтай, олон янзын шинж чанартай байна гэж үздэг. Тэгвэл юм олон талтай нь үнэн боловч чухамдаа бол уг юманд хандах хүний харьцаа олон янз байдагтай холбоотой ойлголт гэж үзэх хэрэгтэй юм. Ийм учраас тухайн юмыг хүн нэрлэхдээ уг юмын ямар шинжийг гол болгож үзсэнээс хамаараад нэг юмыг өөр өөрөөр нэрлэх, тодорхойлох боломжтой байдаг. Бас нэг жишээ авч үзье. Морь унаад давхиж яваа хүний зургийг үзээд монгол хүүхэд эх хэлээрээ юу гэж илэрхийлж байна вэ? гэдгийг нас сэтгэцийн хөгжлийн үечлэлээр нь зааглаж, хооронд нь харьцуулж тодорхойлбол сонирхолтой үр дүн гарна гэсэн үг юм. Уг зургийг “морьтой хүн, морь унасан хүн, морьтой давхиж яваа хүн”, “уралдааны морь унасан хүүхэд”, “наадмын морь”, “уяач хүн”, “уяач хүүхэд”, “адууны хүн”, “морины хүн” гэх мэтээр нэрлэх боломж бий. Үүний зэрэгцээ үүсмэл, ганц үгээр, “адуучин” гэж магадгүй ч зарим хүүхэд “морьчин” гэж хэлж магадгүйг бодолцоно гэсэн үг юм. Гэхдээ 6-14 насныхны хэн нь ч уг зургийг үзээд “агтчин” гэж нэрлэнэ гэж таамаглах бараг хэрэггүй юм. Ингэхлээр юм буюу нөхцөл байдлыг энгийн өгүүлбэр буюу дэлгэрэнгүй өгүүлэмжээр илэрхийлэх, эсвэл ганц үүсмэл үгээр илэрхийлэх нь танин мэдэхүйн хөгжлийн өөр өөр үе шат гэж үзэх ёстой байдаг. Илэрхийллийн энэ хоёр арга нь хийсвэрлэн сэтгэхүйн өөр шинжийг нотлох баримт болдог. Өөрөөр хэлбэл, тарвагачин гэдэг үүсмэл үгийн задлаг хам бүтэц буюу дэлгэрэнгүй өгүүлэмж нь “тарвага агнадаг хүн” болно. Гэтэл дээрх үгтэй адил аргаар үүссэн буюу хэлний ижил айн үзэгдэл болох хоньчин гэдэг үүсмэл бүтцийн утгыг тарвагачин гэдгийнхтэй адилаар бодож “хонь агнадаг, эсвэл төхөөрдөг хүн” гэж тодорхойлж болдоггүй, хонь малладаг хүн гэж өгүүлдэг нь ямар учиртай вэ гэдгийг нэг талаас, сэтгэхүй, хэлний хөгжлийн гарвал хувьслын түгээмэл зүй тогтлын үүднээс авч үзэх, нөгөө талаар, аль нэг тодорхой үндэстэн, эсвэл угсаатны бүлгийн төрөлх соёл, төрөлх хэл, сэтгэлгээний онцлогийн хувьсал хөгжлийн үүднээс өөр өөр арга зүйгээр авч үзэх шаардлагатай болдог.

Энэ бүхнээс дүгнэн үзвэл, монгол хүүхдийн эх хэлээ эзэмшиж буй талаарх нарийвчилсан судалгаа түгээмэл биш байна. Энэ орон зайг нөхөж, монгол хүүхдийн үг, өгүүлбэр бүтээх чадамжийг судалгаа шинжилгээний үндэстэй тогтоох нь хэлний судалгааг хэрэглээтэй болгоход тус дөхөм болно. Монгол хүүхдийн үг, өгүүлбэр бүтээх чадамжийн асуудал нь хүүхэд эх хэлээрээ бодол санаагаа илэрхийлэх чадвар дадал төлөвших үйл явцын онцлогийг нас, сэтгэцийн онцлогоор нь авч үзэхдээ зайлшгүй харгалзах зүйл болно. Ингэснээрээ эх хэлийг сурах үйл явцыг оновчтой болгох үйл ажиллагааны төрөл зүйл, мөн онол, арга зүйн чиг баримжаа гарна гэсэн үг юм. Тодруулбал, эх хэлний сурах бичиг, гарын авлагын агуулга, бүтэц нь сургуулийн насны хүүхдийн танин мэдэхүй, сэтгэхүй, хэлэхүйн үйл ажиллагааны хөгжлийн үе шаттай нарийн уялдаатай байж, тэдний бие бялдрын болон оюун ухаан, хэл ярианы хөгжлийг жигд дэмжихүйцээр байх ёстой болно.

### Abstract

We defined 3<sup>rd</sup> grade child's ability of making sentence only in writing level and the story that chose belongs to three different categories of experiment. For example, in order to study about writing language. Children were made three times essay writing and we collected a list of file.

To define 8 years old Mongolian child's ability of making sentence we made especial experiment that appears at the end of the sentence and conjunction.

### Номзүй

- Баттуяа Ц.** 2003. *Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн хөгжлийг судалсан нь /Цэцэрлэгийн 4-7 настай хүүхдийн жишээн дээр/*. Улаанбаатар.
- Бямбацэрэн Г. нар.** 2018. *Сурагчийн монгол хэлний тайлбар толь (бага анги)*. Улаанбаатар.
- Бэгз Н., Санжаабадам С.** 2018а. *Монголын хүүхэд, залуусын хөгжлийн шалгуур, үзүүлэлтийг тодорхойлох технологийг сургалтын практикт нэвтрүүлэх нь (2013-2017)*. Улаанбаатар.
- Бэгз Н., Санжаабадам С.** 2018б. *Хүүхэд, залуучуудын хөгжлийн онол, арга зүй*. Улаанбаатар.
- Бэгз Н., Санжаабадам С.** 2018в. *Монголын хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих нь Зөвлөмж*. Улаанбаатар.
- Леонтьев А.А.** 1969. *Язык, речь, речевая деятельность*. Москва.
- Монгол хүүхдийн үгийн сангийн чадамж, нөөцийг тодорхойлох нь (төслийн тайлан)*. 2019. Улаанбаатар. (Мөнгөнцэцэг Б., Заяабаатар Д., Эрдэнэ-Очир Т., Золжаргал М., Бямбацэрэн Г., Энхжаргал М., Мөнхбат Ё.)
- Наранцэцэг Ц.** 2007. *Хүүхдийн утгын уялдаатай ярих чадварын судалгаа*. Улаанбаатар.
- Оюунгэрэл Ц.** 2004. *Гурав хүртэлх насны хүүхдийн хэл ярианы хөгжилд үзүүлэх орчны нөлөөлөл*. Улаанбаатар.
- Одончимэг С.** 2014. *Хүүхдийн хэл ярианд үүсмэл үг үүсэх онцлог зүй тогтол (3-6 насны хүүхдийн хэл ярианы ажиглалт, туршилт судалгаа)*. Улаанбаатар.
- Шахнарович А.М., Юрьева Н.М.** 1990. *Психолингвистический анализ семантики и грамматики*. Москва.
- Серебренников Б.А.** 1983. *О материалистическом подходе к явлениям языка*. Москва.
- Ушакова О.С.** 1980. *О причинах детского словотворчества (Психолофизиологическая речевого высказывания)*. Вопросы психологии, №6. Москва.
- Цэндсүрэн Т.** 2002. *5-7 насны хүүхдийн оюун ухаан ба нийгэмшихүйн хөгжлийн хамаарлын судалгаа /Цэцэрлэг, "Хот айл" төсөлд хамрагдаж буй хүүхдүүдийн жишээн дээр/*. Улаанбаатар.
- Цахим сурвалж**  
[www.unicef.org](http://www.unicef.org)  
<http://acei.org/>